

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

АЛС ӨРНӨД ТИВД

(БНМАУ, НҮБ-д элссэний 20жилийн ойд)

Проф. **Дондогийн Цэвэгмид**

Улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагад манай улс хууль ёсны байраа эзэлснээс хойш 20 жил болж байна.

БНМАУ дэлхийн хоёрдугаар дайны үед фашизм, милитаризмын эсрэг тэмцэлд нэгдсэн үндэстнүүдийн талд баттай байж, хүн төрөлхтөнийг фашизмын аюулаас аварсан ЗХУ тэргүүтэй дэвшилт хүчнээс ялалт байгуулахад хувь нэмрээ оруулсан энхийг эрхэмлэгч бүрэн эрхт тусгаар тогтносон улсын хувьд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн байх бүрэн эрхтэй байлаа. Тэгээд НҮБ-д гишүүн байх бүрэн эрхтэйгээ нотолсон өргөдлөө 1946 оны зургадугаар сарын 21-нд анх өгсөн боловч империалист хүчин, тэдний гар хөл бологчдын ялгаварлан гадуурхах бодлогын уршгаар НҮБ-д хууль ёсны байр сууриа эзэлж чадаагүй юм.

Түүнээс хойш манай улс НҮБ-ын гишүүн болох хүсэл эрмэлзлээ удаа дараа илэрхийлэн, ялгаварлан гадуурхах бодлогыг эцэс болгохыг шаардаж байсан боловч империалист гүрнүүд, ялангуяа Чан Кайшийн бүлгийнхнээс «БНМАУ-ын статус нь тодорхой бус, тусгаар тогтносон улс гэхэд ч эргэлзээтэй», «харгис, түрэмгийлэгч улс», «олон улсын үйл ажиллагаанд оролцох туршлагагүй» гэх зэргээр элдэв шалтаг заан манай улсыг НҮБ-ын гишүүн болох явдалд 15 жилийн турш саад хийсэн юм.

Монгол улс нь эрт дээр цагаас тусгаар улс байсан бөгөөд Октябрийн хувьсгалын шууд нөлөөгөөр ялсан 1921 оны ардын хувьсгалын ачаар хувьсгалт шинэ төрийг тогтоон НҮБ бий болохоос олон жилийн өмнө түүний зорилгод нийцсэн энх тайванч гадаад бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ.

1960-аад онд социалист бүтээн байгуулалтдаа монголын ард түмнээс олсон ололт амжилт болон дэлхий дахины хүчний харьцаанд гарсан өөрчлөлт нь тус улсыг НҮБ-д хууль ёсны байр сууриа эзлэх нөхцөлийг бүрдүүлж энэ асуудлыг авч хэлэлцсэн юм. Гэвч уг асуудлыг яг хэлэлцэх үед давах даваа бас л бартаатай, байдал ямраар ч эргэж болох байлаа. Бартаатай тэр давааг даван туулахад манай улсын эрх ашгийг ямагт хамгаалсаар ирсэн ЗХУ, түүний байнгын төлөөлөгчийн газрын тэргүүн Валериан Александрова Зорин маш их чармайлт, дипломат нарийн ур чадвар гарган ажилласны ачаар мөн ах дүү социалист орнууд, Ази, Африкийн дэвшилтэт улсуудын идэвхтэй дэмжлэгийн үр дүнд Ерөнхий Ассамблейн XVI чуулганы 1961 оны аравдугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар БНМАУ-ыг НҮБ-ын гишүүн болгох шийдвэрийг алга ташин батлахыг бид нүдээр үзсэн юм. НҮБ-ын чуулганы их танхимын «Монгол Улс» гэсэн хаяг бүхий ширээнд бид анх удаа сууж, НҮБ-ын

төв ордны өмнө, эрх чөлөө тусгаар тогтнолын ариун бэлэг тэмдэг болсоор ирсэн, алтан соёмбот, төрийн далбааныхаа, очтой, туяатай, гэрэлтэй гэгээтэй, өндөр хүндэтгэлтэй өргөгдөн мандахыг бахдан харж, ёслон зогсож байснаа 20 жилийн дараа өнөөдөр эргэн дурсахад надад таатай байна.

Олон улсын энэхүү байгууллагад төрийнхөө далбааг мандуулж, түүний индэр дээрээс эх орон, нам, засаг, ард түмнээ төлөөлөн анх удаа үг хэлэх их аз завшаан надад олдсоныг би ямагт дурсан санаж байдаг юм.*

IV. Бартаатай давааг давав

1961 оны аравдугаар сарын 25-нд НҮБ-д шинэ гишүүн элсүүлэх асуудлаар Аюулгүйн Зөвлөлийн хурал болов. Зөвлөлт Холбоот Улсын төлөөлөгчдийн шаардлагаар тус улсын асуудлыг Мавританийн түрүүнд хэлэлцэхээр болсон нь чухал ач холбогдол бүхий зүйл байв.

Аюулгүйн Зөвлөлийн гишүүн арван нэгэн улсын төлөөлөгчид хагас тойрог байдлаар засан ширээгээ эзлэн суухад зөвлөлийн дарга модон алхаа тас хийтэл цохиж хурал нээснийг мэдэгдээд энэ өдрийн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд Монгол ба Мавритани улсуудыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр элсүүлэх тухай асуудал байна. Эхлээд Монголын тухай асуудлыг хэлэлцье. Энэ талаар Зөвлөлт Холбоот Улсаас оруулсан тогтоолын төсөл буй гэв.

Зөвлөлийн гишүүдийн нүүр талд ажиглагчдын ширээнээ сууж буй бидний зүг зурагт радиогийн аппаратын дурангууд чиглэж өдий төдий олон сурвалжлагчид энд тэндээс маань фото зураг авч гэрэл гялс хийнэ.

Зөвлөлт Холбоот Улсын төлөөлөгч нөхөр В. А. Зорин үг хэлэх зөвшөөрөл авч тус улсын эртний түүхээс эхлээд одоогийн хөгжил дэвшлийг дурдаж БНМАУ-нь НҮБ-ын гишүүн байх хууль ёсны эрхтэй болохыг нотлон яриад Монголыг НҮБ-д гишүүнээр авах тухай Зөвлөлт Холбоот Улсаас оруулсан тогтоолын төслийг Аюулгүйн Зөвлөл нэгэн дуугаар батлахыг уриалав.

Дараа нь Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний нэг Либерти улсын төлөөлөгч Монгол улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх явдлыг дэмжинэ гэв.

Түүний дараа Зөвлөлийн даргаас Хятадын төлөөлөгч үг хэлнэ гэв.

Америкийн империалистуудын дуулгаварт зарц Чан Кайшийн төлөөлөгч тус улсыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнд элсүүлэхээс татгалзаж удаа дараа хориг тавьж байсныг бид сайн мэдэх учир тэрээр одоо юу хэлдэг бол гэж анхааран суув.

Том хүрээтэй нүдний шилтэй, намхан биетэй, буурал үстэй өвгөн ширээний микрофоныг ойртуулж түүхийн үнэн баримтыг үзтэл гуйвуулсан гүтгэлгийн үгээ хэлж эхэллээ. Монгол бол 13 дугаар зууны үеэс эхлэн Хятадын хамт байсан түүний салшгүй хэсэг юм гэх зэргээр аль ч улсын түүхчний амнаас гаршгүй, эрүүл ухаантай хэний ч зүрхэлж өгүүлш-

*Манай улсыг 1962 онд НҮБ-д элсэхэд улс, эх орон, ард түмнээ төлөөлөн оролцсон төлөөлөгчдийн тэргүүн, манай нам төрийн ахмад зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч, сурган хүмүүжүүлэгч Дондогийн Цэвэгмидийн бичсэн «Алс Өрнөд тивд» хэмээх замын тэмдэглэлээс зохиогчийн зөвшөөрөлтэйгээр хэсэгчилэн нийтэлж манай улс НҮБ-д элссэний 20 жилийн ойд зориулав. Уг тэмдэглэл зохиолчийн 1974 онд хэвлэгдсэн түүвэрт бүрэн эхээр бий. (ред)

гүй худал үгсийг хэлэхийн завсартаа нүднийхээ шилнийхээ хүрээн дээгүүр давуулж бид нар тийш байн байн хялалзан харна.

НҮБ-ын байгууллагад хууль бусаар суугаа Чан Кайшийн төлөөлөгч үндэсгүй гүтгэлгийн үгнийхээ төгсгөлд Мавритани улсыг НҮБ-д гишүүнээр элсэх явдлыг дэмжихийн тул аргагүйн эрхэнд хавчигдаж Монголын талаар санал хураахад оролцохгүй гэв.

Америкийн Нэгдсэн Улсын төлөөлөгч Монгол улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх тухай тогтоолд санал хураахад түдгэлзэнэ гэв.

Франц, Английн төлөөлөгчид тус улсын НҮБ-д элсэх хүсэлтийг урьд жилүүдэд хэлэлцэх үед тэднийхэн ямар байр суурь эзэлж, хэрхэн эргэлзэж түдгэлзэж байсан тухай баахан яриад Монголыг НҮБ-д гишүүнээр элсүүлэхэд зөвшөөрөх санал өгнө гэв.

Дараа нь Нэгдсэн Араб Улсын төлөөлөгч хэлсэн үгэндээ НҮБ-ын гишүүнд элсэх өрөгдлөө аль хэдий нь 1946 онд өгсөн Монгол улс тус байгууллагын гишүүн байх ёстой юм. Зөвлөлт Холбоот Улсын төлөөлөгчийн хэлсэн үг маш зүйтэй, Монголыг НҮБ-д элсүүлэх тухай зөвлөлгөө-шийдвэр өгсөн тогтоолын төслийг Аюулгүйн Зөвлөл нэгэн дуугаар батална байх гэж бодож байна. Харин Мавританийг дэмжиж чадахгүй гэв.

Цейлоны төлөөлөгчдөөс Монгол улсын НҮБ-ын гишүүн болох явдалд баяртай байгаагаа дурдаж урьд хэлэлцэх үед үргэлж дэмжсээр ирсэн тухайгаа болон Цейлон нь эрт цагаас эхлэн манай оронтой соёлын талаар харилцаатай байсныг тэмдэглэв. Мөн хоёр жилийн өмнө өөрийн биеэр Монгол оронд очиж үзэхэд ард түмнийхээ хүчээр аж ахуйгаа дээшлүүлж айл хөрштэйгээ харилцаа байгуулахыг хичээж дэвшин хөгжиж байгаа улс байсан гэх зэргээр манай ололт амжилтыг магтан яриад НҮБ-ын гишүүн болох явдлыг нь дэмжинэ гэв.

Дараа нь Экватор, Чили, Турк улсын төлөөлөгчид тус улсыг НҮБ-ын гишүүн болгох явдлыг дэмжих саналаа тайлбарлан яриу.

Ингээд Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүд болох Зөвлөлт, Америк, Англи, Франц хууль бусаар суудал эзэлж байгаа Чан Кайшийнхан байнгын бус зургаан гишүүд, Либери, Нэгдсэн Араб улс, Цейлон. Экватор, Чили, Туркийн төлөөлөгчид тус улсыг НҮБ-ын гишүүнд элсүүлэх тогтоолын төсөлд хэрхэн санал өгөх нь тодорхой болов.

Аюулгүйн Зөвлөлийн дүрмээр аль нэг асуудлыг байнгын таван гишүүд санал нэгтэй шийдвэрлэх ёстой бөгөөд хэрэв эдгээр тавын аль нэг нь татгалзвал уул асуудал батлагддаггүйг бид мэдэж байлаа.

Иймээс хэрэв Чан Кайшийн төлөөлөгч санал хураахад үл оролцож, Америкийн төлөөлөгч түдгэлзвэл Аюулгүйн Зөвлөлийн бусад есөн гишүүд зөвшөөрч манай улсыг НҮБ-ын гишүүнд элсүүлэх асуудал Аюулгүйн Зөвлөлөөр нааштай шийдвэрлэгдэх нь гэж бид баяртай байв.

Аюулгүйн Зөвлөлийн даргаас Монгол улсыг НҮБ-ын гишүүнд элсүүлэхээр тус зөвлөлөөс гаргах шийдвэрийн төслийг ЗХУ-аас оруулжээ. Үүнийг батлахаар санал хураахад бэлэн болов гэх үес Чан Кайшийн төлөөлөгч ухасхийн босож танхимаас гарч одох нь гэнэт гэдэс нь мушгилсан хүний байдалтай харагдаж билээ.

Санал хураасны дүнд зөвлөлийн гишүүдээс ес нь зөвшөөрч нэг нь (АНУ) түдгэлзэн тус улсыг НҮБ-ын гишүүн болгох асуудал Аюулгүйн Зөвлөлд олонхийн саналаар шийдвэрлэгдсэнийг зөвлөлийн даргаас зарлав.

Зөвлөлт Холбоот Улсын төлөөлөгч нөхөр Зорин, Чан Кайшийн төлөөлөгчийн гүтгэлгийг няцааж дахин хэлсэн үгэндээ Чан Кайшийнхны төлөөлөгч нь монголын тусгаар тогтносон бүрэн эрхт улс болохыг зөвшөөрч 1945 онд НҮБ-д дэмжиж байсан үгийг үндсэн эх баримтаас нь иш татаж уншаад хятадыг төлөөлж чадахаа больсон энэ үед Монголын тусгаар тогтнолыг үгүйсгэх үндэсгүй гүтгэлгийн аргад шилжиж байгааг хурц мэргэнээр тэмдэглэн ярихад Чан Кайшийн төлөөлөгч суудал дороосоо гижигдүүлсэн юм шиг тэсэж ядан өндөлзөж шар харандаагаа гозолзуулан үг хэлэх зөвшөөрөл гуйв.

Хятадын хувьсгалын дөлөнд хуйхлагдан түлэгдэж Тайвань арал дээр зугадаж гарсан Чан Кайшийнхны төлөөлөгч аанай л улиг домог болсон гүтгэлгийн үгээ давтахыг оролдохдоо 1946 онд монголыг тусгаар тогтносон улс гэж бодож байсан юм. Гэтэл Монголын цэрэг хятадын хил руу довтолсон учраас тийм биш болохыг мэдэж бид байр сууриа өөрчилсөн билээ гэж хэдхэн минутын өмнө хэлж байсан үгээ өөрөө няцаав.

Аюулгүйн Зөвлөлийн хурал тармагц ах дүү социалист болон Ази, Африкийн олон орны төлөөлөгчид ирж бидэнд баяр талархал хүргэв. Түүнчилэн Мавританийн төлөөлөгчид ирж бидэнтэй гар гараасаа барилцан зургаа авахуулав. Фото ба сонин сурвалжлагчид биднийг хүрээлэн тойрч зурагт буулгах буюу энэхэн тэрхнийг асуун Аюулгүйн Зөвлөлийн танхимаас гаргахгүй нилээд цаг удав.

Дараа өдрийн «Нью-Йорк Таймс» сонинд тус улсыг НҮБ-ын гишүүнд элсүүлэхээр Аюулгүйн Зөвлөлөөс шийдвэр гаргасныг бичсэн ба Монголын асуудлаар санал хураах үед Чан Кайшийн төлөөлөгч жорлонд гүйж орсон гэдэг үнэн үү гэж төлөөлөгчид харилцан бие биенээсээ асуулцан инээлдэн шог болгож арчаагүй болсон Чан Кайшийн байр суурийг тухай Нью-Йорк даяар шуугин ярилцаж байв.

V. Хууль ёсны суудлаа эзлэв

1961 оны аравдугаар сарын 27-ны өдөр үдээс хойш 3 цагт Ерөнхий Ассамблейн чуулганы хуралдаан болов. НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын ёслолын хэлтсийн эрхлэгч биднийг дагуулан Ассамблейн их танхимд оруулж ажиглагчдын суудалд байр зааж өгөөд ойролцоохон хүлээн зогсож байв.

Бул чулуу олонтой, бартаа ихтэй даваа болох Аюулгүйн Зөвлөлийг амжилттай туулан шулуун замд орлоо. Чуулганы бүгд хуралд ах дүү социалист болон Ази, Африк, Латин Америкийн орнуудын зэрэг дэмжих хань, түших нөхөд олонтой гэж төгс итгэл төрөгдөн хуралдагсад болон Ассамблейн их танхимын байдлыг сонирхон харж суув.

Ассамблейн танхим дугариг бөгөөд бөмбөгөр дээвэртэй учир монгол гэрийн хэлбэртэй санагдана. Өмнөх өндөр тайз дээр ногоон гантиг ширээнээ чуулган дарга суужээ. Түүний өмнө саарал хөх гантигаар үйлдсэн илтгэгчийн индэр байх бөгөөд илтгэх хүний биеийн өндөр намын байдалд тохируулж микрофоныг өргөх буулгах зэргээр цахилгаан үйлдлийн хүчээр хялбархан зохицуулж байх нь харагдана.

Чуулган даргын ширээний ар оройн хана ташуу бөгөөд хурц шар өнгөтэй, түүний дээр НҮБ-ын сүлд тэмдгийг зуржээ. Тэнхимийн дугариг хана туургыг дагуулан оргаан хөгжмийн хонгио мэт алтан шар өнгөтэй урт модон хөндий савхуудыг унжуулсан нь дуу чимээ чангаруулах зохилдолгоо бөгөөд энэ танхимын аль ч өнцөгнөөс аяархан ч ярихад

хаана ч томруун тодоор сонсогдоно. Танхимын төв хэсэгт төлөөлөгчдийн 1100, тойрон хэсэгт зочдын 816, ар талын давхарлаг хэсэгт сурвалжлагчдад зориулсан 234 сандал байдаг гэнэ. НҮБ-ын гишүүн улс бүхний нэрийг төлөөлөгчдийн суудлын өмнө, ширээн дээр тавьжээ.

Энэ өдрийн бүгд хуралд нэг ч сул суудал үзэгдэхгүйг бодвол хоёр мянга гаруй хүн цугларсан бололтой.

Чуулган дарга шар модон алхаа тас хийтэл цохиж НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 16 дугаар чуулганы 1043 дугаар бүгд хурлыг нээснийг мэдэгдэв.

Хэлэлцэх хэргийн төлөвлөгөөний анхдугаар зүйлд атомын радиацийн тухай тогтоолын төслийг хэлэлцэж батлах асуудал байсан бөгөөд Канад улсын төлөөлөгчөөс мөнхүү тогтоолын төслийн А ба Б зүйлүүдийг тус тусад нь санал хураахыг шаардсанаар саланги санал хураалтыг явуулах болов.

Удсан ч үгүй сайхь тогтоолын төсөлд санал хураалгаж гүйцээд чуулганы даргаас НҮБ-д гишүүдийг элсүүлэх тухай асуудалд орьё. Эхлээд Монголыг хэлэлцүүлнэ. Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнд элсүүлэхээр 23 улс тогтоолын төсөл оруулсан байна гэхэд нь их танхимд нэгэн зэрэг анир чимээгүй нам гүм болов.

Зөвлөлт Холбоот Улсын төлөөлөгчдийн тэргүүн нөхөр В. А. Зорин босож илтгэгчийн индэр дээр гарахын чацуу «Ноён даргаа» гэж чуулганы даргын зүг нэгэн удаа бөхөсхийгээд хэлэх үгээ эхлэв.

Нөхөр В. А. Зорин Аюулгүйн Зөвлөлөөс Монгол улсыг НҮБ-ын гишүүн болгохоор шийдвэр гаргасныг дурдаад монголчуудын эрт дээр цагаас улс төрийг байгуулж ирсэн түүхээс эхлэн одоогийн шинэ Монголын цэцэглэн хөгжсөнийг тодорхой баримтаар дэлгэрэнгүй тодорхойлон НҮБ-ын гишүүн байх манай хууль ёсны эрхийг бахдам сайхан хамгаалж ярьсан үгийнхээ төгсгөлд Монгол Улсыг НҮБ-ын гишүүнд элсүүлж Ерөнхий ассамблейн чуулганаас гаргах тогтоолын төслийг дор дурдсан 23 улс оруулав гэж улс тус бүрийг нэрлэн заагаад мөнхүү тогтоолын төслийг нэгэн дуугаар батлахыг итгэж байгаагаа илэрхийлэв.

Дараа нь Чан Кайшийн төлөөлөгч босож манай улсын тусгаар тогтнолыг үгүйсгэсэн улигт гүтгэлгээ давтаж гадаад монгол нь НҮБ-ын дүрмээр түүний гишүүн байх ёсгүй билээ хэмээн ямар ч хууль, эрх, түүхийн нотолгоогүй гадуурхлын явцуу үг чалчсаны эцэст санал хураахад үл оролцоно гэж мэдэгдэв.

Үг хэлэх өөр төлөөлөгч гарсангүй, тэнхимд чимээгүй нам гүм ажээ. Чуулган дарга төлөөлөгчдийн зүг эргэн тойрон харж өчүүхэн зуур хүлээгээд үг хэлэх, санал гаргах хүсэлтэй бусад хүмүүс гаргахгүйд тогтоолын төслийг батлуулъя гэхэд нь бүх төлөөлөгчид нижигнэтэл алга ташив.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнд санал нэгтэй батлагдав гэж чуулганы даргаас зарлан мэдэгдээд шар модон алхаа тас хийтэл цохиж орхив. Чуулганы төлөөлөгчид дахин алга ташив.

Чуулган даргаас ёслолын хэлтсийн эрхлэгчид хандаж Монголын хүндэт төлөөлөгчдийг зохих суудалд нь урин суулгана уу гэхэд НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын ёслолын хэлтсийн эрхлэгч бидний өмнө ирж босохыг урив.

Бид төлөөлөгчдийн дундуур явж «Монгол» гэсэн гарчиг бүхий хууль ёсны суудлаа эзлэн суухад тэнхим дүүрэн нижигнэтэл алга ташсаар л

байсан ба ах дүү социалист болоод, Ази, Европ, Латин Америкийн олон орны төлөөлөгчид баяр талархал илэрхийлэн гар барьцгаана.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын албаны хэл нь орос, англи, франц, испани, хятад боловч эхний үгийг төрөлх хэлээрээ хэлэхийг чуулган дарга зөвшөөрсөн учир монгол үг анх түрүүн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өндөр индэр дээрээс хангинан цууриатаж энэ өдрөөс эхлэн монголын төлөөлөгчид НҮБ-ын 16 дугаар чуулганы ажилд оролцож эхлэв.

VI. НҮБ-д Монголын далбаа хийсэв

Нэгдсэн Үндэстний Байгууллагын ордны өмнө Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн далбааг өргөн хийсгэх ёслол 1961 оны аравдугаар сарын 31-ний өдөр болов. Энэ ёслолд бүх социалист болон Ази, Африкийн орнуудын төлөөлөгчид, Ерөнхий Ассамблейн 16 дугаар чуулганы дарга, Аюулгүйн Зөвлөлийн дарга, НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын орлогчид зэрэг олон тооны албаны хүмүүс оролцов.

Далбаа хийсгэх өндөр баганын ёроолд манай төлөөлөгчдийн тэргүүнийг зогсоогоод чуулган даргаас баяр хүргэж үг хэлмэгч НҮБ-ын хамгаалалтын албаны нэгэн дарга олсны үзүүрээс татаж тус улсын төрийн далбааг баганын оройд өргөн тогтоов.

Эрт дээр цагаас эхлэн эрх чөлөө, тусгаар тогтнолын ариун бэлэг тэмдэг болсоор ирсэн алтан соёмбо үсэгтэй, дундаа хөх тэнгэрийн өнгөтэй, хоёр тал нь гал улаан далбаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв ордны өмнө бусад зуун улсын төрийн далбаануудын дунд намилзан мандах нь олноос онцгой, очтой туяатай, түмнээс түрүүнд, гэрэлтэй гэгээтэй мэт бидэнд санагдаж байлаа.

Фото сурвалжлагчид гавшгайлан гүйлдэж зурагт буулгана. Сонин сурвалжлагчид элдвийг сонирхож биднийг дагана. Чуулган дарга болон НҮБ-ын албаны хүмүүс, бусад цугларагсад, ах дүү орны төлөөлөгчид ирж баяр хүргэн бидний гарыг барина. Нэгэн хэсэг ийнхүү баяр хөгжлийн байдлаар НҮБ-ын үүдэнд бужигнасны дараа Ерөнхий Ассамблейн 16 дугаар чуулганы 1045 дугаар бүгд хурал нээгдэв. Энэ хурал дээр Польш, Индонези, Чехословак, Куба, Белорусс, Болгар, Албани, Камбож, Унгар, Украин, Румын, Балба, Зөвлөлт Холбоот Улсын зэрэг төлөөлөгчид Монгол Улсын Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн болсон явдалд баяр хүргэж халуун дотно үг хэлэв.

Ийнхүү 1961 оны аравдугаар сарын 27-ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улс ий манай хэзээний анд нөхөр Зөвлөлт Холбоот Улс ба бусад социалист орнууд болон Ази, Африкийн төвийг сахигч улс гүрнүүдийн халуун дэмжлэгтэйгээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн болж дэлхийн олон улсын дунд хууль ёсны байр сууриа эзэлсэн билээ.

НА ЗАПАДНОМ ДАЛЕКОМ КОНТИНЕНТЕ

(Резюме)

Д. Цэвэгмид

В октябре 1981 года исполнилось 20 лет с момента вступления МНР в ООН. Этим событиям посвящена публицистическая статья главы монгольской делегации; присутствовавшей при принятии МНР в ООН, профессора Д. Цэвэгмида.

Еще в 1946 году МНР было подано заявление о вступлении в ООН. Однако вследствие враждебной позиции, занятой империалистическими странами и представителем гоминдановского Китая, МНР не могла сразу занять законное место в ООН. Они объяснили это «неопределенным международным статусом МНР».

В 60-е годы изменения, происшедшие в международной обстановке, ощутимые успехи в строительстве социализма в нашей стране, поддержка стран социализма, а также миролюбивых государств Азии и Африки привели к тому, что на XVI сессии Ассамблей ООН 27 октября 1961 года представители МНР заняли свое место в ООН.

Автор, как очевидец, живо описывает обстановку, которая царила на Ассамблее при принятии МНР в членство ООН, дипломатические усилия, предпринятые представителем СССР в ООН В. А. Зориным, и противодействия представителя Чан Кайши.